



Монгол улсад ургамлын идээлэгт сарлагийн арьс, шир болон био-арьс, био-савхин бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадавхийг бэхжүүлэх нь



Дэлхийн арьс ширний зөвлөл /LWG/
болон OEKO-TEX стандартын
удирдамж

Мэдэгдэл

Энэхүү гарын авлагыг Европын Холбооны санхүүжилттэй “Сарлагийн арьс шир ба био-арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд боловсруулсан бөгөөд Европын Холбооны албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.

Агуулга

2.1	Хураангуй.....	4
АРЬС ШИР ҮЙЛДВЭРЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН “ДЭЛХИЙН АРЬС ШИРНИЙ ЗӨВЛӨЛ” (LWG)-ИЙН УДИРДАМЖ		5
Дэлхийн арьс ширний зөвлөл /LWG/-ийн танилцуулга		5
2.2	БҮЛЭГ 1 – ҮЙЛДВЭРИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	5
2.3	БҮЛЭГ 2 – ТУСЛАН ГҮЙЦЭТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	6
2.4	3-Р БҮЛЭГ – НИЙГМИЙН АУДИТ	6
2.5	БҮЛЭГ 4 – ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗӨВШӨӨРӨЛ	7
2.6	БҮЛЭГ 5 – ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ	8
2.7	БҮЛЭГ 6 – ГАРАЛ ҮҮСЛИЙГ МӨШГИХ (ОРЖ ИРЖ БУЙ МАТЕРИАЛ)	9
2.8	БҮЛЭГ 7 – ГАРАЛ ҮҮСЛИЙГ МӨШГӨХ (ГАРЦ МАТЕРИАЛ).....	10
2.9	БҮЛЭГ 8 – БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН СИСТЕМ	10
2.10	БҮЛЭГ 9 – ХОРИОТОЙ БОДИС, НИЙЦЭЛ, ХРОМ VI-ИЙН МЕНЕЖМЕНТ	11
2.11	БҮЛЭГ 10 – ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭ.....	14
2.12	БҮЛЭГ 11 – УСНЫ ХЭРЭГЛЭЭ	14
2.13	БҮЛЭГ 12 – АГААРЫН БОЛОН ДУУ ЧИМЭЭНИЙ БОХИРДОЛ ТҮҮНИЙ ЯЛГАРАЛ	15
2.14	БҮЛЭГ 13 – ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ.....	17
2.15	БҮЛЭГ 14 – БОХИР УС ЦЭВЭРЛЭГЭЭ	18
2.16	БҮЛЭГ 15 – ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙ.....	19
2.17	БҮЛЭГ 16 – ХИМИЙН БОДИСЫН МЕНЕЖМЕНТ	21
2.18	БҮЛЭГ 17 – ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЕНЕЖМЕНТ	24
ОЕКО-ТЕХ® СЕРТИФИКАТ-Д БЭЛТГЭХ УДИРДАМЖ		26
2.19	ТАНИЛЦУУЛГА ба ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ- ОЕКО-ТЕХ® СТАНДАРТ	26
2.20	ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ ЯВЦ.....	28
2.21	ТУРШИЛТ БА ХЯЗГААРЛАЛТ	30
2.22	ТУХАЙН ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР ДЭЭР ХИЙХ АУДИТ.....	31
2.23	ОЕКО-ТЕХ® СЕРТИФИКАТ АВАХАД БЭЛТГЭХ ЗҮЙЛС	34
ХАВСРАЛТ		36
1.	LWG Арьс, шир үйлдвэрлэгчийн аудитын тайлан – Дугаар 7.2.3	36
2.	Хавсралт 4: ОЕКО-ТЕХ стандартын бүтээгдэхүүний ангилалд тохирох хязгаарлагдмал утгууд.....	36
3.	Хавсралт 5: ОЕКО-ТЕХ стандартад заасан бодисууд.....	36

2.1 Хураангуй

Энэхүү тайланд кластерийн гишүүд Дэлхийн арьс ширний зөвлөлд (LWG) нэгдэх болон OEKO-TEX стандартын гэрчилгээ авахад туслах тусгай удирдамж багтсан болно.

Энэхүү гарын авлагын зорилго нь кластерийн гишүүн байгууллагуудад дэлхийн арьс ширний зөвлөл (LWG)-д нэгдэх болон OEKO-TEX стандартыг нэвтрүүлэх өргөдөл гаргахад шаардлагатай мэдээ мэдээлэл, зааварчилгааг өгөх юм.

Энэхүү гарын авлагаар дамжуулан LWG-ийн гишүүн бус арьс ширний үйлдвэрлэгчдэд LWG аудитын үндсэн зарчмуудыг ойлгох мөн байгаль орчин, нийгэмд үзүүлж буй нөлөөллийн гүйцэтгэлийг үнэлэх, сайжруулах шаардлагатай хэсгүүдийг тодорхойлоход туслах бөгөөд LWG аудитад бэлэн эсэхээ шалгах боломжтой болно.

Төслийн баг нь дараах 17 чиглэлээр Кластерийн чадавхийн иж бүрэн үнэлгээг хий хэд дэмжлэг үзүүлэн ажиллах юм. Үүнд: Үйлдвэрийн ерөнхий бүтэц, туслан гүйцэтгэгч, нийгмийн аудит, үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн тоон мэдээлэл, гарал үүслийн орц, гарцын мөшгилт, хяналт, байгаль орчны менежментийн систем, хориотой бодис, эрчим хүчний хэрэглээ, усны хэрэглээ, агаар/дуу чимээний ялгаруулалт, хог хаягдлын менежмент, хаягдал ус цэвэрлэх, эрүүл мэнд аюулгүй байдал, онцгой байдлын бэлэн байдал, химийн бодисын менежмент ба үйл ажиллагааны менежмент.

Мөн LWG болон STeP by OEKO-TEX® гэх мэт бусад гэрчилгээжүүлэлтийн чиглэлээр (ашиг хүртэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн) техникийн дэмжлэг үзүүлэн ажиллах юм.

АРЬС ШИР ҮЙЛДВЭРЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН “ДЭЛХИЙН АРЬС ШИРНИЙ ЗӨВЛӨЛ” (LWG)-ИЙН УДИРДАМЖ

Дэлхийн арьс ширний зөвлөл /LWG/-ийн танилцуулга

LWG аудитын протоколын хамгийн сүүлийн хувилбар (2023 онд хэвлэгдсэн 7.2.3 дугаар) нь доор дурдсан 17 хэсгийг агуулна.

1. Үйлдвэрийн ерөнхий мэдээлэл
2. Туслан гүйцэтгэгч үйл ажиллагаа
3. Нийгмийн аудит
4. Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
5. Үйлдвэрлэлийн тоон мэдээлэл
6. Гарал үүслийг мөшгих (орж ирж буй материалын)
7. Гарал үүслийг мөшгих (гарц материалын)
8. Байгаль орчны менежментийн систем
9. Хориотой бодисын жагсаалт, нийцэл, хром VI
10. Эрчим хүчний хэрэглээ
11. Усны хэрэглээ
12. Агаар, дуу чимээний ялгаруулалт
13. Хог хаягдлын менежмент
14. Хаягдал ус цэвэрлэ
15. ХАБЭА төлөвлөгөө
16. Химийн бодисын менежмент
17. Үйл ажиллагааны менежмент

Аудитын хэсэг бүр хэд хэдэн асуултаас бүрдэнэ. Аудиторуудын бүртгэсэн хариултын дагуу аудит хийлгэж буй талд оноо өгдөг. Эцсийн онооны үндсэн дээр аудит, хүрэл, мөнгө, алт зэрэг шагналуудыг олгоно.

Асуулт бүрийн хариултыг мэдээлэл, бичиг баримт болон/эсвэл гэрэл зурагтай хамт хавсаргах шаардлагатай бөгөөд энэ нь шалгуулагчийн өгсөн хариултуудыг үнэн зөв болохыг баталгаажуулахад оршино. Зарим тодорхой асуултуудад нотлох баримт дутуу байх нь хасах оноо авахад хүргэж, эсвэл бүр аудитыг автоматаар амжилтгүй болгодог.

Аудитын протоколд үйлдвэрлэлийн өгөгдөл зэрэг тооцоолол, баталгаажуулалтын хугацаа, дахин аудит хийх шаардлага, тайлбар толь болон төрөл бүрийн техникийн үзүүлэлтүүдийн талаархи мэдээлэл багтана.

Компанийн нэрийн өмнөөс өөр байршил дахь үйлдвэрлэлийн орчинд туслан гүйцэтгүүлэгчээр үйл ажиллагааг эрхэлж байгаа тохиолдолд туслан гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд үнэлгээ хийх шаардлагатай бөгөөд энэ нь хориотой бодис болон гарал үүслийг мөшгих хэсэгт нэмэлт дэлгэрэнгүй тайлбар өгөх шаардлага үүсдэг.

2.2 БҮЛЭГ 1 – ҮЙЛДВЭРИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1-р хэсэг нь аудиттай холбоотой асуудлуудыг хариуцдаг байгууллага болон ажилтаны дэлгэрэнгүй мэдээлэл орно.

Тодруулбал, үйлдвэртэй холбоотой танилцуулах мэдээллүүдийг нэгтгэнэ. Үүнд: байгууллагын нэр, регистрийн дугаар, газарзүйн солбицол байршил, хаяг, нийт талбайн хэмжээ, холбоо барих мэдээлэл (утасны дугаар, имэйл хаяг). Мөн байгаль орчны асуудлыг хариуцдаг ажилтантай холбоо барих дэлгэрэнгүй мэдээлэл шаардлагатай.

Үйлдвэрийн ерөнхий мэдээлэл болон үйл ажиллагаа явагдаж буй бүс нутгийн төлөвлөгөө чухал бөгөөд ирэх 3 жилд байгаль орчны үнэлгээ, үйл ажиллагаа, өөрчлөлт хийх шаардлагатай томоохон хэмжээний барилгын төсөл эсхүл боловсруулалт/үйлдвэрлэл, ашиглалтын өөрчлөлттэй холбоотой ажил төлөвлөгдсөн бол заавал тэмдэглэх шаардлагатай.

Мөн, бусад байгууллагын өмнөөс ямар нэгэн үйл ажиллагаа эрхэлдэг бол үйлчлүүлэгчдийн холбоо барих мэдээлэл, тэдний эзэмшиж буй бүтээгдэхүүний хувь хэмжээг тэмдэглэх хэрэгтэй. Түүнчлэн компани нь тухайн байгууллагад ажиллаж буй ажилчдын тоо, ажиллах хуваарь, ажлын өдрүүдийг тодорхой зааж өгөх шаардлагатай.

Мөн туслан гүйцэтгэгчийн боловсруулсан бүтээгдэхүүний хамгийн бага гарцыг шалгах бөгөөд тухайн хугацаанд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний гарц 25,000 хавтгай дөрвөлжин метр, 25,000 ширхэг эсвэл 175 тонноос бага байвал тухайн үйлдвэрлэгч аудит болон баталгаажуулалтад хамрагдах эрхгүй болохыг анхаарна уу.

2.3 БҮЛЭГ 2 – ТУСЛАН ГҮЙЦЭТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хоёрдугаар хэсгийг зөвхөн байгууллагын нэрийн өмнөөс өөр газарт нэг буюу хэд хэдэн үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд хэрэглэнэ.

Энэ хэсэгт хоёр жагсаалт багтана:

1. "LWG аудитын протокол"-оор үнэлэгдсэн туслан гүйцэтгэгчдийн жагсаалтыг гаргахад ашиглана.
2. "Туслан гүйцэтгэгчийн аудитын протокол"-оор үнэлэгдсэн туслан гүйцэтгэгчдийн жагсаалтад хэрэглэнэ.

Аль ч жагсаалтад туслан гүйцэтгэгч тус бүрийн байршил, үйл ажиллагааны хүрээ, мөн дэлхийн арьс ширний зөвлөлийн (LWG) аудитын оноог хамт тэмдэглэнэ.

Аудит эхлэхээс өмнө туслан гүйцэтгэгчдийн дэлгэрэнгүй мэдээллийг аудиторт заавал өгсөн байх шаардлагатай. Хэрэв шаардлагатай мэдээлэлээр хангаагүй бол аудитор аудит үргэлжлүүлэх эсэхийг шийдэх ба үргэлжлүүлээгүй тохиолдолд -40 оноо авна, эсхүл шаардлагатай хугацаанд аудит хийх боломжгүй гэж үзсэн тохиолдолд аудит амжилтгүй болох эрсдэлтэй юм.

Энэ бүлгийн сүүлийн асуулт нь туслан гүйцэтгэгч бүрийн бутархай оноог тооцоолоход ашиглагдана. Энэ оноог туслан гүйцэтгэгчийн аудитын оноог туслан гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд зарцуулсан нийт эрчим хүчний хувь хэмжээгээр үржүүлж гаргана.

2.4 3-Р БҮЛЭГ – НИЙГМИЙН АУДИТ



Энэ хэсэг нь тухайн байгууллагыг бие даасан үнэлгээгээр нийгмийн хариуцлагаа нотлон харуулж чадах эсэхийг тодорхойлох зорилготой. Энэхүү жагсаалтыг LWG-д хүсэлт гаргаж батлуулсаны үндсэн дээр дэлгэрүүлж болно. Протоколын дараа дараачийн хувилбаруудад энэ хэсэг нэн чухал юм. Байгууллага нь нийгмийн аудитын систем эсвэл аудитын байгууллагаар дамжуулан аудит хийх шаардлагатай. LWG (Дэлхийн арьс ширний зөвлөл)-ийн хүлээн зөвшөөрөгд аудитын систем, аудитын байгууллагуудын мэдээлэл

бүхий жагсаалтыг LWG-ийн веб хуудсанд байршуулсан байдаг.

Асуулт 1: тухайн үйлдвэр сүүлийн ашигласан аудитын хөтөлбөр, аудитын байгууллага 24 сарын дото нийгмийн аудитад хамрагдсан бол LWG-н аудит эхлэхээс өмнө мэдээлэл хүргэх хэрэгтэй.

Асуулт 2: үйлдвэр нь LWG-ийн хүлээн зөвшөөрдөг нийгмийн аудит хийлгэсэн бол магадлан итгэмжлэл нь LWG-ийн аудит хийлгэх үед хүчин төгөлдөр байгаа эсэхийг гэрчилгээний зураг, гүйцэтгэлийн хураангуй, эсвэл тайлан дүгнэлт хэлбэрээр өгөх шаардлагатай.

Асуулт 3: сүүлийн 24 сарын хугацаанд хийгдсэн нийгмийн аудитын явцад илэрсэн ноцтой буюу хүлээн зөвшөөрөх боломжгүй асуудлууд бүртгэгдсэн эсэхийг тодруулах юм.

Асуулт 4: Компаний сүүлийн 24 сарын хугацаанд нийгмийн аудит хийлгэж нийцлийн зөрчил илэрч түүнийгээ тухайн аудитын үед шийдвэрлээгүй асуудал байгаа эсэхийг тодруулж бүртгэнэ. Зөрчлийн шинж чанар, залруулах арга хэмжээ(үүд)-ийг тодорхой бичиж, аудитын байгууллага, аудит хийгдсэн огноо болон тухайн зөрчлийг засах ёстой дуусах хугацааг зааж өгөх шаардлагатай.

2.5 БҮЛЭГ 4 – ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗӨВШӨӨРӨЛ

Энэхүү хэсэгт тухайн үйлдвэр нь холбогдох тусгай зөвшөөрөл, лиценз, болон орон нутгийн хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг шалгадаг 7 асуултаас бүрдэнэ. Мөн аливаа зөрчил, сэрэмжлүүлэг, торгуулийн талаарх мэдээлэл, холбогдох засвар, залруулах арга хэмжээний мэдээллийг бүрдүүлсэн байх шаардлагатай.

Арьс шир үйлдвэрлэгч нь аудит эхлэхээс өмнө үнэлгээ хийхэд шаардлагатай бүх зөвшөөрлүүд бэлэн байгаа талаарх баталгааг аудиторт гаргаж өгөх шаардлагатай /хуулбар хувийг урьдчилан өгөх боломжтой/. Аудиторыг урьдчилан, бие даан ямар төрлийн зөвшөөрөл шаардлагатайг тодорхойлоход нь шаардагдах холбогдох байгууллагын албан тушаалтны нэр, холбогдох мэдээллийг арьс үйлдвэрлэгч аудиторын шаардсаны дагуу гаргаж өгч болзошгүй.

Асуулт 1: Компани үйл ажиллагаа эрхлэх бүх зөвшөөрлүүд, тэдгээрийн дуусах хугацааг харуулсан бүртгэл хөтөлж байгаа эсэхийг шалгана. Үүнд: нэр, зөвшөөрөл олгосон байгууллага, олгосон огноо, хүчинтэй хугацаа, сунгах өргөдөл гаргасан огноо, тайлагналын давтамж, хамгийн сүүлд ирүүлсэн тайлангийн огноо зэрэг мэдээллүүд багтсан байх шаардлагатай.

Асуулт 2: Шаардлагатай үйл ажиллагааны зөвшөөрлийн бүртгэлтэй холбоотой байна. Үүнд: Байгаль орчны хаягдал/ялгаруулалттай холбоотой нэг цогц зөвшөөрлүүд /эсхүл арьс шир үйлдвэрлэгчид хамааралтай зохицуулах хягаарлалт/ байна. Мөрдлөг болгож байгааг нотлох зорилгоор шинжилгээний бүх тайланг гарган өгөх бөгөөд энэ нь компанийн туршилтын горимын бүрэн бүртгэл байна.

- Усны хаягдлын тухайд, өдөр/долоо хоног/сар/жилд ялгарах усны хэмжээ болон усанд агуулагдах химийн болон биологийн хүчилтөрөгч, азот, хориотой бодис, хлорид, хүнд металлууд гэх мэт бодисуудын бүртгэгдсэн утгуудыг агуулсан байх шаардлагатай.
- Агаарын ялгарлын хувьд, ялгарах хэмжээ, үнэр, дуу чимээ, тоосонцор, VOC (дэгдэмхий органик нэгдлүүд)-ын талаарх мэдээллийг багтаах ёстой.
- Хатуу хог хаягдал, уурын зуухны зөвшөөрөл мөн химийн бодис худалдан авах, хадгалахтай холбоотой аливаа зөвшөөрлийг аудиторт өгөх ёстой.
- Барилга байгууламжийн тогтвортой байдал болон түүнтэй холбоотой аливаа зөвшөөрлийг аудиторт үзүүлэх шаардлагатай байж болно.

Эдгээр зөвшөөрөл, тайлангууд нь аудитын чухал хэсэг болж, байгууллагын хууль ёсны болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хянахад чухал үүрэгтэй.

Асуулт 3: Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний хүрээнд аливаа сэрэмжлүүлэг, торгуулийг бүртгэхээс гадна засч залруулах арга хэмжээний нотлох баримтыг хавсаргана. Мөн өмнөх зохицуулалт, засч залруулах арга хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл, тэдгээрийн огноог тодорхой бичих ёстой.

Асуулт 4: Компани сүүлийн 24 сарын хугацаанд албадан хэрэгжүүлэх зохицуулалтын арга хэмжээ эсхүл торгуулийн талаар мэдээллийг LWG-д мэдэгдсэн эсэхийг лавлана. Мөн ийм мэдэгдэл гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гарсан эсэхийг баталгаажуулна.

Асуулт 5, 6: Үйлдвэрлэлийн орчин олгосон зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг зохицуулах байгууллагаас ямар давтамжтайгаар ирж шалгадаг эсэхийг тодруулна. Мөн сүүлчийн хийсэн шалгалтаар ямар нэгэн хэрэгжүүлэх, сайжруулах шаардлага тавигдсан бол түүнийг тодорхой бичиж мэдээлэх шаардлагатай.

Асуулт 7: Үйлдвэр нь олгогдсон зөвшөөрөл холбогдох хууль тогтоомж эсхүл хязгаарлалт үйлдвэр нь зөвшөөрлийн шаардлага, орон нутгийн/үндэсний хууль тогтоомж, орон нутгийн/үндэсний хэмжээнд ялгаруулалтын хязгаарлалтын хэмжээ гэх мэт/-ийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй эсэхийг тодруулна. Хэрэв энэ талаар нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд аудит амжилтгүй болно. Холбогдох нотлох баримт бичиг дутмаг эсвэл хасах оноо авсан тохиолдолд аудит амжилтгүй болох магадлалтай.

Эдгээр асуултууд нь байгууллагын зохицуулалттай холбоотой хэрэгжилт, нийцлийг баталгаажуулж, байгаль орчинд үзүүлэх нөлөөг зохицуулахад чухал ач холбогдолтой юм.

2.6 БҮЛЭГ 5 – ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

Энэхүү хэсэг нь арьс ширний ханган нийлүүлэлтийн сүлжээг холбож, хагас боловсруулсан материал, түүхий эд ханган нийлүүлэгчдийн эрсдэл, үнэлгээг үнэлэх зорилготой. Хагас боловсруулсан материалаас үйлдвэрлэлээ эхлүүлэгчдийн хувьд тэдний ханган нийлүүлэгчид аудитын үйл явцад хэрхэн оролцож байгааг нь LWG үнэлнэ. Энэ хэсгийн дагуу үнэлгээ хийх, хийхгүйг туслан гүйцэтгэгчийн үйл ажиллагааны хамрах хүрээнээс шалтгаалан шийдвэрлэн.



Протоколд "туслан гүйцэтгэгч"

(оролт, гаралт аль аль нь) гэсэн тодорхойлолтыг оруулсан бөгөөд нийлүүлэгчдээс авсан материалыг хянан шалгахад ямар мэдээлэл шаардлагатайг заасан байдаг. Үүнээс гадна, арьс ширнийг тус үйлдвэрлэлийн орчны нэр/ баримт бичиг мэдээллүүдийг тодруулна.

Асуулт 2: Аудитын үйлдвэрлэл, эрчим хүчний зарцуулалт, усны зарцуулалтын хэсгүүдийг дараалсан 24 сарын мэдээлэлд үндэслэж тодорхойлно.

Асуулт 3, 4: Тухайн байгууллагын үйлдвэрлэлийн төрлийг тодорхойлох (жишээ нь, шинэ арьс, дэвтээсэн арьс, шохойдсон хуулдас арьс, пикл арьс, вэтбло арьс шир, краст, хуулдас гэх мэт) юм. Мөн үйлдвэрийн явуулж буй үйл ажиллагааг тодорхойлно. **Жишээ нь:** түүхий арьс идээлэхээс эхлээд гүйцэт боловсруулалт хүртэлх үйл ажиллагааг тодорхойлно. Эдгээр асуултууд нь жилийн турш үйлдвэрлэсэн арьс/ширийн тоо, жин болон үйлдвэрлэсэн талбайн хэмжээг (м.кв) лавлан асуух болохыг анхаараарай.

Асуулт 5: Тухайн байгууллага туслан гүйцэтгэгчээр ажил гүйцэтгүүлж байгаа эсэх, тэдгээр байгууллагуудын үйл ажиллагааны цар хүрээ, үйлдвэрлэсэн арьс ширний нийт талбайг асууна.

Асуулт 6: Тухайн байгууллагыг жижиг эсвэл том хэмжээний арьс ширний үйлдвэрлэгч эсэхийг тодорхойлохын тулд хэрэглэсэн материалын масс болон бүтээгдэхүүний талбайн хэмжээг тонноор лавладаг.

Асуулт 7: Үйлдвэрлэсэн арьсны жин, зузаан задаргааг задаргааг тодруулан асууна.

Асуулт 8: Тухайн байгууллагын арьс, ширний үйлдвэрлэлийн үйл ажиллагааны төрлийг тодорхойлохын тулд тэдгээрийн хувь хэмжээг асууна. Үйл ажиллагааг арьс, ширний төрлөөр (тугалын арьс, нүүртэй арьс, нубук гэх мэт) болон бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаагаар (хувцас, гутал, бүрээс гэх мэт) ангилна. Мөн идээлгийн төрлийн талаар мэдээлэл өгөх шаардлагатай. Жишээ нь, хром, ургамлын идээлэг эсвэл хромгүй идээлгийн талаар мэдээлэлийг хангах хэрэгтэй. Мөн идээлэг, краст, эцсийн гэх гарцыг тодорхойлно.

Асуулт 9-15: асуултууд нь тухайн байгууллагад ханган нийлүүлэлт хийдэг үйлдвэрлэгчдээс LWG-ийн аудит хийлгэсэн болон хийлгээгүй үйлдвэрлэгчдийн тоо мэдээллийг тодорхойлно. Мөн хагас боловсруулсан материал нийлүүлдэг арьс шир үйлдвэрлэгчид, боловсруулагчид, худалдаачдын талаархи мэдээллийг цуглуулдаг. Үүнд тэдний нэр, байршил, нийлүүлж буй материалын төрөл, LWG-ийн үнэлгээ байгаа эсэх, нийлүүлэлтийн сүлжээний хувь зэрэг багтана.

Асуулт 16: Сүүлийн 24 сарын хугацаанд хийсэн нийлүүлэлтийн сүлжээний хувь хэмжээг асууна. Ханган нийлүүлэгчдийг LWG-ийн үнэлгээнд үндэслэн ангилдаг бөгөөд өндөр үнэлгээ авсан ханган нийлүүлэгч байгууллагуудад илүү өндөр оноо өгдөг.

Асуулт 17: эцсийн бүтээгдэхүүнтэй харьцах харьцааг тодруулна. Үүнд: идээлгийг үйлдвэрлэлийн орчинд гүйцэтгэдэг, компани хүлээн авахаас өмнө хийсэн идээлгэ, пикл хүртэл боловсруулсан хувийг тодруулан асууна. Хэрэв 100% гэж үзвэл 18-25-р асуултад хариулах шаардлагагүй.

Асуулт 18-25: Эдгээр асуултууд нь идээлгийн явцад хромын хэрэглээтэй холбоотой мэдээллийг цуглуулна.

- 18-р асуултад тухайн байгууллагаас хром болон хромгүй аргаар идээлж буй бүтээгдэхүүний эзлэх хувийг тодорхой болгох хэрэгтэй бөгөөд хэрэв хромгүй аргаар идээлсэн бол илүү өндөр оноо авдаг болохыг анхаараарай. .
- 19-22-р асуултууд нь арьс идээлгийн үе шатуудад хромын агууламжийг хэмжих давтамжийг асууна. Давтамж ихтэй байвал илүү өндөр оноог цуглуулна.
- 23, 24-р асуултууд нь түүхий эсвэл пикл арьс/ширийн идээлэгт ашигласан хромын хэдэн хувь нь байгаль орчинд нэвтрэхгүй байхаар хэрэглэж эсхүл цэвэрлэдэг эсэхийг тодруулна. Энд байгаль орчны аюулгүй хаягдлыг харгалзан үздэггүй. Энэ хоёр асуулт нь оноо тооцоолох тэгшитгэлд оролцдог.

Асуулт 25: Энэ хэсгийн сүүлийн асуулт нь 23, 24-р асуултуудад ашигласан хог хаягдлын шинжилгээг ямар давтамжтайгаар хийдэг болохыг лавлана.

2.7 БҮЛЭГ 6 – ГАРАЛ ҮҮСЛИЙГ МӨШГИХ (ОРЖ ИРЖ БУЙ МАТЕРИАЛ)

Энэ хэсэгт арьс шир үйлдвэрлэгчид хүлээн авч буй материалынхаа гарал үүслийг тодорхой бойны газар эсхүл бүс нутаг хүртэл мөшгөх чадварыг үнэлнэ. Мөн энэ хэсэгт гарал үүслийн улсууд, ашиглаж буй мөшгөх системийн талаарх мэдээллийг оруулна. Үйл ажиллагааны хамрах хүрээнээс шалтгаалан туслан гүйцэтгэгчдийг энэ хэсгийн дагуу үнэлэх эсхүл үнэлэхгүй байх магадлалтай.

Асуулт 1: Ирж буй материалын гарал үүслийн бойны газар эсхүл бүс нутгаас эхлэн мөшгөх аргыг тодорхойлсон бичмэл журам байгаа эсэхийг асууна. Хэрэв байгаа бол дараагийн асуултуудад дэлгэрэнгүй тайлбарлах шаардлагатай болно.

Асуулт 2: Энэхүү асуултыг дөрвөн хэсэгт хуваана:

- 2a: Бойны газраас ирсэн арьс/ширэнд бойны газрыг тодорхойлохуйц биет тэмдэглэгээ байгаа эсэхийг шалгана.
- 2b: Хэрэв тэмдэглэгээ хийгдээгүй бол тухайн арьс/ширтэй холбоотой баримт бичигт бойны газрыг тодорхойлсон эсэхийг шалгана.
- 2c: Ханган нийлүүлэгч нь ирж буй хагас боловсруулсан арьс/шир бүрийг тусад нь биет байдлаар тэмдэглэж, тухайн арьс шир нь бойны газарт хамаарахыг мөрдөж болж байгаа эсэхийг тодруулна.
- 2d: Хүлээн авсан арьс ширийг гарал үүслийг бойны газар хүртэл нь мөшгөх боломжгүй боловч ханган нийлүүлэгчийн байршил газарзүйн байршлыг ашиглан тодорхойлох боломжтой эсэхийг шалгана.

Эдгээр дөрвөн асуулт нь тухайн байгууллага арьс, ширийг ямар улсаас авдаг талаар судалж, нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг тодорхой аргачлалаар тооцож, судлах боломжтой арьс, ширний жагсаалтыг гаргахыг шаарддаг.

Асуулт 3a-3d: асуултуудад дээрх дөрвөн аргын хувьд байгууллагын ашиглаж буй мөшгөх системийн дэлгэрэнгүй тайлбарыг өгөх шаардлагатай: арьс/ширэнд биет тэмдэглэгээ хийх, бойны газраас гарсан ачааг баталгаажуулах баримт бичиг, газарзүйн лавлагааг ашиглан бүтээгдэхүүний гарал үүсэлтэй эсэхийг тодорхойлох баримт бичиг гэх мэт.

Асуулт 4-7: Бразил болон Парагвай улсаас арьс, шир авдаг бойны газруудын мөшгөх системийг тайлбарлахад чиглэсэн. Эдгээр асуултууд нь ой мод устгах, уугуул иргэдийн газар нутгийг хамгаалахад анхаарч ажилладаг бойны газруудыг сонгоход хамаатай. Мөн бойны газрууд хамгийн бага шаардлага хангасан байх ёстой бөгөөд эдгээрийг газарзүйн лавлагаа болон нийлүүлсэн материалын тоо хэмжээ, нотлох баримттай хамт жагсаан үзүүлдэг.

Асуулт: 8-11: Бразил болон Парагвайгаас бусад улс орнуудаас арьс/шир нийлүүлдэг бойны газруудын талаар судалдаг. Эдгээр асуулт нь мөн дээр дурдсан 2a-аас 2d-д заасан дөрвөн аргачлалын аль нэгэнд үндэслэгдсэн байдаг.

Асуулт 12: Асуулт6-аас 11-р асуултын оноонд үндэслэн нийт эх үүсвэрийн хүчин зүйлийг тооцоолоход ашиглагддаг.

Асуулт 13: байгууллага ховор зүйлийн арьсыг боловсруулсан бол хууль ёсны гарал үүсэл, мөшгөх системийг тодорхойлоход ашигладаг. Хэрэв тухайн ховор арьсны гарал үүслийг 100%-иас бага хувьтай тогтоосон бол аудит амжилтгүй болно.

2.8 БҮЛЭГ 7 – ГАРАЛ ҮҮСЛИЙГ МӨШГӨХ (ГАРЦ МАТЕРИАЛ)

Энэ хэсэгт арьс шир үйлдвэрлэгчид өөрсдийн үйлдвэрлэлийн үйл явцдаа түүхий эдээ мөшгөх чадварыг үнэлнэ. Мөн гарч буй түүхий эд (үйлдвэрлэлийн орчноос гарч буй материал)-ийг хэрхэн тодорхойлох аргачлал, тодорхойлогчийн боловсруулалтын үе шат бүр дээр бүртгэгдсэн тоон мэдээллийг авч болох боломжийн зэргээр үнэлнэ. Нэг багц арьс шир гэдэг нь нэг хүрдэнд хамт боловсруулсан бүх арьс шир юм. Энэ хэсэгт 5 асуулт багтсан болно:

Асуулт 1: Байгууллага нь үйлдвэрлэлийн явцад материалын гарал үүслийг хэрхэн хянаж буйг тодорхойлсон бичмэл журам байгаа эсэхийг тодруулна. Хэрэв арьс бүр биет тэмдэглэгээтэй байсан ч, материалын мөрдөгдөх байдлыг хангаж буй тодорхой бичмэл журам хэрэгтэй. Түүнчлэн, багцын код нь тухайн арьсанд ашигласан жор, материалын төрөл, болон эх үүсвэрийг (шууд нийлүүлэгч) мэдээлэх ёстой.

Хоёрдугаар асуулт: Багцын материалыг эх үүсвэрээс эцсийн шат хүртэл мөрдөж болох процедурыг тодруулна. Арьс/шир бүрийн тэмдэглэгээ болон багцын эх үүсвэрийг (эсвэл нийлүүлэгчдийн бүлэг) тодорхойлох нь оноог тооцоход ашиглагдана.

Гуравдугаар асуулт: Энэ асуулт хоёр хэсэгтэй:

Эхний хэсэгт, байгууллага нь биет тэмдэглэгээтэй арьс/ширний мөрдөгдөх системийн дэлгэрэнгүй тайлбарыг өгөх ёстой. Зураг заавал шаардагдана.

Хоёрдугаар хэсэгт, байгууллага нь бүх багц бүтээгдэхүүний материалын үйлдвэрлэлийн шат дамжлагаар хэрхэн мөрдөж болох талаар бичиг баримтад тулгуурлан тайлбар гаргах ёстой. Зураг шаардлагагүй ч, зөвлөдөг.

Дөрөвдүгээр асуулт: Хэрэв үйлдвэрлэгч нь "Зэрлэг амьтан, ургамлын ховордсон төрөл зүйлүүдийн олон улсын худалдааны тухай конвенц" (CITES)-д хамаарах материал боловсруулдаг бол шаардлагатай хууль ёсны зөвшөөрөл, таних бичиг баримтуудыг бүхэлд нь баталгаажуулж, материалын гарал үүслийг бүрэн тодорхойлох ёстой. Хэрэв мөрдөгдөх чадвар 100% батлагдаагүй бол аудит амжилтгүй болсонд тооцогдоно.

Тавдугаар асуулт: Үйлдвэрлэлийн явцад арьсны салгасан хэсгүүдийг (вет блү эсвэл краст) биет тэмдэглэгээгээр хянахтай холбоотой. Үйлдвэрлэгч нь материалын биет тэмдэглэгээний эсвэл баталгаат баримт бичгүүдийн тусламжтайгаар бүтээгдэхүүний гарал үүслийг мөрдөх чадварт үндэслэн оноо авна.

2.9 БҮЛЭГ 8 – БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН СИСТЕМ

Энэ хэсгийн асуултууд нь байгууллагын байгаль орчны асуудлуудыг хэрхэн удирдаж, хянаж буйг үнэлэхэд чиглэсэн бөгөөд байгаль орчны удирдлагын тогтолцооны үр нөлөөг тодорхойлохын тулд хийгддэг.

Асуулт 1: Байгууллагад байгаль орчны талаарх бичмэл бодлого байгаа эсэхийг асууна. Хэрэв уг бодлого нь ердөө нэг догол мөрөөс бүрдсэн бол 1 оноо, харин илүү нарийвчилсан, дэлгэрэнгүй бодлого нь 3 оноо авна.

Асуулт 2: Байгаль орчны бодлогыг байгууллагын ажилтнуудад мэдээлсэн эсэхийг шалгана. Хэрэв бодлогын талаар мэдээлэл өгсөн бол зэрэг оноо авна. Харин мэдээлэл дутуу эсвэл байхгүй бол хасах оноо өгнө.

Асуулт 3: (хоёр хэсэгтэй):

Эхний хэсэгт, хууль тогтоомж болон хэрэглэгчийн шаардлагад нийцсэн байгаль орчны бичигдсэн журам байгаа эсэхийг асууна.

Хоёр дахь хэсэгт, уг журмыг хэрэгжүүлсэн эсэхийг нотлохыг шаардана. Үүнд хуулийн шаардлага болон хэрэглэгчдийн хязгаарласан бодисуудын жагсаалтын бүртгэл багтана. Бүртгэл нь шинэчлэгдсэн байх ёстой. Хэрэв бүртгэл байхгүй бол тухайн журамд нийцэж байгааг өөр байдлаар батлах шаардлагатай.

Асуулт 4: (хоёр хэсэгтэй):

Эхний хэсэгт, байгаль орчны хамгааллын дор хаяж 5 зорилт тавьсан бичмэл журам байгаа эсэхийг асууна. Эдгээр зорилтын хоёр нь тоон үзүүлэлттэй байх шаардлагатай. Хоёр дахь хэсэгт, компани нь эдгээр зорилтуудыг биелүүлсэн гэдгийг батлах нотолгоо гаргана.

Асуулт 5: (хоёр хэсэгтэй):

Эхний хэсэгт, байгаль орчны зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц, хариуцлагын талаар бичмэл журам байгаа эсэхийг шалгана.

Хоёр дахь хэсэгт, эдгээр журмыг амжилттай хэрэгжүүлсэн нотолгоог гаргана. Энэ нь зорилтуудыг яагаад сонгосон, гүйцэтгэлийн зорилтыг хэрхэн тодорхойлсон зэргийг багтаана.

Асуулт 6: (хоёр хэсэгтэй):

Эхний хэсэгт, ажилтнууд байгаль орчны зорилтыг ойлгож байгаа эсэхийг батлах журам байгаа эсэхийг шалгана.

Хоёр дахь хэсэгт, ажилтнуудад жилд дор хаяж нэг удаа сургалт хийдэг эсэх, мөн төслийн удирдагч болон гишүүдийн мэргэжлийн туршлагаар зорилтыг хэрэгжүүлсэн эсэхийг нотолно.

Асуулт 7: (хоёр хэсэгтэй):

Эхний хэсэгт, байгууллага байгаль орчны удирдлагын тогтолцооны баримт бичгийг хэрхэн хөтлөх талаар журамтай эсэхийг асууна.

Хоёр дахь хэсэгт, энэ журмыг хэрэгжүүлсэн эсэхийг нотлох баримт шаарддаг.

Асуулт 8: (гурав хуваагдана):

- Эхний хэсэгт, байгаль орчны дотоод аудит хийх журам байгаа эсэхийг асууна. Журмын гарчиг, лавлагааны дугаарыг оруулах шаардлагатай.
- Хоёр дахь хэсэгт, аудит ямар давтамжтай явагддагийг батлах нотолгоог гаргана.
- Гуравдугаар хэсэгт, дотоод аудиторыг хэн болохыг, мөн тэр хүн үндэсний гэрчилгээтэй эсвэл мэргэжлийн зөвлөхөөр бэлтгэгдсэн байх ёстойг тодорхойлно.

Асуулт 9: (гурав хуваагдана):

- Эхний хэсэгт, байгаль орчны үнэлгээ хийх журам байгаа эсэхийг шалгана. Журмын гарчиг, лавлагааны дугаар шаардлагатай.
- Хоёр дахь хэсэгт, үнэлгээг тодорхой хугацаанд хийдэг гэдгийг нотлох баримт гаргана.
- Гуравдугаар хэсэгт, удирдлагын хяналтын хорооны гишүүдийн жагсаалт шаардлагатай.

Асуулт 10: Байгаль орчны асуудлыг хариуцдаг хүн хэнд тайлагнадаг вэ гэдгийг шалгана (төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал гэх мэт).

Асуулт 11: Байгаль орчны асуудал, нөлөөллийн шинжилгээ хийсэн эсэхийг асууна. Энэ асуултад нотлох баримт шаардлагатай

Асуулт 12: Байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулахын тулд талуудын шинжилгээг ашигласан эсэхийг нотлох баримт шаарддаг.

2.10 БҮЛЭГ 9 – ХОРИОТОЙ БОДИС, НИЙЦЭЛ, ХРОМ VI-ИЙН МЕНЕЖМЕНТ

Энэхүү хэсэгт үйлдвэр нь хэрэглэгчдийн зүгээс Хориотой бодист тавьдаг шаардлагыг хэрхэн зохицуулж, ойлгож, хэрэгжүүлдэг болохыг үнэлнэ. Энэ хэсэгт хром VI үүсэх эрсдлийг бууруулахад компанийн авч хэрэгжүүлж буй арга хэмжээг үнэлнэ. 100 хувь туслан гүйцэтгэгчийн хувиар ажилладаг арьс шир үйлдвэрлэгчид энэ хэсэг хамаарахгүй. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг гэрээлсэн үйлчлүүлэгч бүтээгдэхүүн дэх хориотой бодисын менежментийг хариуцна. Өөрийн материал болон туслан гүйцэтгэгчийн хувиар материал үйлдвэрлэдэг арьс шир үйлдвэрлэгчдийн хувьд өөрийнх нь материал дахь хориотой бодисын менежментийг үнэлнэ. Туслан гүйцэтгэгчдийн үйл ажиллагааны хамрах хүрээнээс шалтгаалан энэхүү хэсгийн дагуу үнэлэх эсхүл үнэлэхгүй байх магадлалтай.

Энэхүү протоколд зориулан LWG хромгүй арьс ширийг тодорхойлохдоо хуурай арьс ширний жинд үндэслэн 1000 мг/кг-аас бага хэмжээний хром агуулсан арьс шир юм. Энэ хэмжээг одоогоор ашиглагдаж буй стандартууд (BS EN 15987)-ад үндэслэн гаргасан.

Тус хэсгийн эхний хэсгийн асуултууд Хориотой бодисын жагсаалт (ХБЖ)-тай холбоотой. Хэрэглэгчид болон брэндүүд өөрсдийн худалдан авч буй материалд хэрэгцээгүй бодис агуулагдаж байгаа эсэхийг хянах, хязгаарлах зорилгоор ХБЖ-ыг ашигладаг. Арьс шир үйлдвэрлэгч нь ХБЖ-аа гаргаж өгөөгүй хэрэглэгчдэд нийлүүлэх арьс ширний ХБЖ-ыг боловсруулах ёстой. ХБЖ нь арьс ширэнд хамаарах боловч арьс шир үйлдвэрлэхэд ашигласан химийн бодисонд хамаарахгүй.

Хоёр дахь хэсгийн асуултууд нь өөрийн үйлчлүүлэгч болон ХБЖ-ын аль алиных нь нийцлийг хангах зорилгоор арьс шир үйлдвэрлэгч компани нь өөрийн ханган нийлүүлэгчдээр мөрдүүлэх Хориотой бодисын жагсаалттай холбоотой. Энэ тохиолдолд ХБЖ нь хүлээн авч буй хагас боловсруулсан материалд хамаарна. Компани нь гарч буй бүтээгдээгдэхүүний ХБЖ-ын нийцлийг хангах зорилготой.

16 дахь хэсэг болох “Химийн бодисын менежмент” дэх асуултууд нь Үйлдвэрлэлд Хориотой бодисыг жагсаалт (ҮХБЖ)-тай холбоотой. Арьс шир үйлдвэрлэлд ашигладаг химийн бодис дахь хэрэгцээгүй бодисыг хянах, хязгаарлах зорилгоор ҮХБЖ-ыг ашигладаг. ҮХБЖ нь арьс шир үйлдвэрлэлд ашигладаг химийн бүтээгдэхүүнд хамаарах боловч арьс ширэнд хамаарахгүй. Энэ хэсгийн хэд хэдэн асуултад арьс ширний багцын талаар дурьдсан байгаа. Үйлдвэрлэлийн нэг хүрдэнд ачаалагдан боловсруулагдсан арьс ширийг анхаарч, жижиг дээж боловсруулалтын ачааллыг анзаарахгүй өнгөрч болно. Хүлээн авсан материал нь краст байдаг үйлдвэрлэгчдийн хувьд нэгдмэл байдлаар цуг боловсруулсан арьс ширний багцыг нэг багц арьс гэж тооцох ёстой

Асуулт 1: Тухайн компанид хориотой бодисын менежментийн тогтолцоо болон/эсвэл хориотой бодисын журам бичгээр баталгаажсан байгаа эсэхийг тодруулан асууна.

Асуулт 2: Үйлчлүүлэгчдийнхээ хориотой бодисын үзүүлэлтийг тодорхойлох зорилгоор компани тухайн үйлчлүүлэгчидтэйгээ хэрхэн харилцдаг талаар асууна. Энэ асуултад гэрэл зургийн нотлох баримтыг хамруулах шаардлагатай.

Асуулт 3: Компанид гарч буй арьс ширэнд тавьдаг хориотой бодисын үзүүлэлт байдаг эсэхийг тодруулахаас гадна үйлчлүүлэгчийн үзүүлэлт байхгүй тохиолдолд техникийн үзүүлэлт байгаа эсэхийг тодруулна.

Асуулт 4: Компаниас бүх үйлчлүүлэгчийн үзүүлэлтүүдийг болон компанийн нийцлийг бүртгэж, шинэчлэгдсэн мэдээллийг хадгалахыг шаарддаг. Бүртгэлд дараах мэдээллийг оруулах ёстой: Холбогдох огноо болон харилцах арга, хариу өгсөн огноо, лавлагааны дугаар, дэлгэрэнгүй хяналтын огноо

Асуулт 5: Үзүүлэлтүүдийг 6 эсвэл 12 сарын хугацаатайгаар тогтмол шалгаж байх ёстой. Хэрэв хяналт нь бага давтамжтай бол оноо авахгүй. Шалгалтыг батлах нотолгоог аудиторт үзүүлэх шаардлагатай.

Асуулт 6: Хоёр хэсэгт хуваагдана.

- ба-д компани дотооддоо хориотой бодисын тодорхойлолтод заасан хязгаарлалттай байх ба тэдгээр бодисуудын талаар мэдээлэх ёстой. Үүнд хром VI, формальдегид, хлоржуулсан парафин зэрэг бодисууд багтана. Энэ хэсгийн оноо нь компанийн техник үзүүлэлтүүдэд суурилсан бодисын хязгаарлалтаас хамаарна. Илүү хатуу буюу доод хязгаарт илүү өндөр оноо өгнө. Мөн, хэрэв компанийн үйлдвэрлэсэн арьсыг хүүхдийн бүтээгдэхүүнд ашигладаг бол формальдегидийн нэмэлт хязгаарлалтыг тодорхой заах ёстой.
- Асуултын хоёрдугаар хэсэг нь хүнд металлын хязгаарлалтад хамаарна. Хэрэв эдгээр хязгаарын аль нэг буюу хэд хэдэн үзүүлэлт нь тодорхойлогдоогүй бол энэ хэсэгт оноо өгөгдөхгүй. Мөн эхний хэсэгтэй адил, арьс ширийг хүүхдийн бүтээгдэхүүнд ашигладаг тохиолдолд кобальт, зэс, хар тугалга зэрэг хүнд металлын нэмэлт хязгаарлалтыг заах шаардлагатай.

Асуулт 7: Хориотой бодисын менежментийн тогтолцооны талаархи дэлгэрэнгүй мэдээллийг лавладаг. Үүнд: туршилтын давтамж, гуравдагч талын туршилтын байгууллагуудын мэргэшил, итгэмжлэл, бүтээгдэхүүний шугамын тодорхойлолт багтана.

Асуулт 8: Бүтээгдэхүүний шугамын талаар нарийвчлан лавладаг. Үүнд: гол 3 бүтээгдэхүүний шугамыг нэрлэж, үйлдвэрлэлд эзлэх хувийг нь заах шаардлагатай. Мөн

энэ асуултанд хязгаарлалттай бодисын хяналтын хүрээнд бүтээгдэхүүний шугамыг хэрхэн тодорхойлсон талаар тайлбар өгдөг.

Асуулт 9: Компани нь шинжилгээ хийлгэдэг лаборатори нь ISO 17025 стандартын гэрчилгээтэй эсхүл үйлчлүүлэгчдийн хүлээн зөвшөөрсөн шинжилгээ хийдэг байгууллага болохыг нотлохыг шаарддаг.

Асуулт 10: Гарч буй краст болон гүйцэд боловсруулсан арьс ширийг гуравдагч этгээдийн хориотой бодисын шинжилгээнд хамруулсан тохиолдол ямар давтамжтайгаар хийгддэг эсэхийг тодорхойлоно.

Асуулт 11: Гуравдагч талын шинжилгээнд 1-9-р асуултуудад дурдсан журмын дагуу хийгдсэн эсэхийг нотлох баримтыг шаардана.

Асуулт 12 ба 13: Үйлчлүүлэгч эсхүл арьс шир үйлдвэрлэгчийн хориотой бодисын тодорхойлолт дахь Хром VI-ийн нийцэлээс үл хамааран гарч буй бүх арьс ширийг ISO17025-ын баталгаажсан лабораторит (эсвэл үйлчлүүлэгчийн санал болгосон) шинжлүүлэх замаар үйлдвэрлэлийн стандарт <Зррт ISO17075-д нийцэж байгаа эсэхийг лавлана. Гарч буй краст болон гүйцэд боловсруулсан арьс ширийг Хром VI-гийн шинжилгээнд хамруулсан тохиолдол гарсан эсэхийг лавлана.

Асуулт 14: Идээлсэн арьс ширэн дэх хром VI-ийн шинжилгээний давтамжийг лавладаг бол.

Асуулт 15: Компанид Хром VI-ийн зөрчлийн үед авах хариу арга хэмжээ, цаашид энэ үзэгдлийг багасгах/устгах тухай үр дүнтэй журам байгаа эсэхийг лавладаг.

Асуулт 16: Сүүлийн 2 жилийн хугацаанд Хром VI-ийн зөрчил гарсан тохиолдол байгаа эсэхийг лавлана.

Асуулт 17 ба 18: компанийн үйлчлүүлэгчийн хориотой бодисын үзүүлэлтийг ямар хэмжээнд дагаж мөрдөж байгаа эсэхийг шалгадаг. Компанийн өөрийн хориотой бодисын үзүүлэлтийг ямар хэмжээнд дагаж мөрдөж байгаа эсэхийг лавлана. Дагаж мөрдөж байгааг нотлох баримт гаргах ёстой бөгөөд алдаа гарсан тохиолдолд шалтгааныг тодорхойлж, холбогдох бүтээгдэхүүний шугамыг дахин шалган, үндсэн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээнүүдийг авсан байх ёстой. Дараах асуултууд нь орж ирж буй материалыг шалгахад зориулагдсан.

Асуулт 19: тус компани орж ирж буй бүх хагас боловсруулсан арьсанд хориотой бодисын өөрийн үзүүлэлттэй эсэхийг лавлана.

Асуулт 20: компани нийлүүлэгчдээс хоиротой бодисын талаарх нотолгоо (туршилтын тайлан, мэдэгдэл гэх мэт) шаардаж байгаа эсэхийг лавладаг

Асуулт 21: Арьс шир үйлдвэрлэгч нь ийм төрлийн мэдээллийг архивд хадгалж байгаа эсэхийг шалгадаг бөгөөд, архивласан мэдээллийн тоо ононд нөлөөлдөг (холбоо барьсан огноо, хариу авсан огноо, жилд ашигладаг материалын хэмжээ гэх мэт).

Асуулт 22: Үйлдвэрлэлийн явцад хэрэглэгдэж буй химийн бодисыг өөр бодисоор солих үед ямар журам баримталдаг талаар лавлана.

Асуулт 23-25: Орж ирж буй арьс болон хром агуулсан химийн бодисуудыг баталгаажуулах шинжилгээ хийж тэдгээрийн хром VI-ийн агууламжийг зохистой хэмжээнд байгаа эсэхийг лавладаг.

Асуулт 26-28: "wet blue" буюу нойтон хөх арьс болон тухайн газарт боловсруулсан материал дахь байгалын өөх тосны агууламжийг шалгахад ашиглагддаг, учир нь тосны агууламж тодорхой хувиас хэтэрвэл хром VI үүсэх эрсдэлтэй байдаг.

Асуулт 29-33: Дахин идээлгийн шат дамжлага нь pH-ийн утгууд, исэлдүүлэгч бодисууд болон тосжилтын бодисуудын талаар лавладаг, учир нь эдгээр нь Хром VI үүсэхэд нөлөөлж болзошгүй. Нэмэлтээр, химийн боловсруулалтад оролцдог туслан гүйцэтгэгчид RSL (хориотой бодисын жагсаалт) шаардлагыг мөрдөж байгаа эсэхийг шалгах асуултуудыг багтаадаг.

2.11 БҮЛЭГ 10 – ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭ

Энэ хэсэгт үйлдвэрлэсэн нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашигласан эрчим хүчийг үнэлэх бөгөөд үүний дотор туслан гүйцэтгүүлсэн үйл ажиллагаа багтана. Үйлдвэрлэлийн орчинд үйлдвэрлэсэн сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг үнэлгээгээр тооцно.

Энэ хэсгийн оршилд өгөгдлийг цуглуулахад ашиглагдах хугацааны дэлгэрэнгүй мэдээлэл болон арьс, зүсэлтүүд, шохойн болон пикл арьсыг боловсруулсан хүчин зүйлсүүдэд аудит хийх талаар багтсан.

Эхний хоёр асуулт нь туслан гүйцэтгэгчдийн жагсаалт, тэдний гүйцэтгэж буй ажиллагаанууд, боловсруулсан арьсны талбай болон нэг метр квадрат арьс үйлдвэрлэхэд ашигладаг эрчим хүчний хэмжээг (сэргээгдэхгүй эрчим хүчний эх үүсвэрээс авсан нь 1-р асуулт, сэргээгдэх эх үүсвэрээс авсан нь 2-р асуулт) лавлана.



3-р асуулт нь 4 хэсэгт хуваагддаг. Эхний хэсэг нь жилд ашиглагддаг түлшний төрөл, тогтвортой эсэх, өөрөө үйлдвэрлэсэн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашигласан эсэх мөн хувиргасан эсэх мэдээллийг хүснэгтлэх шаардлагатай. Мөн хийгддэг үйл явцын талаар мэдээлэл өгөх ёстой (жишээ нь, түүхий арьснаас нойтон хөх арьс хүртэл, эсвэл түүхий арьснаас эцсийн бүтээгдэхүүн хүртэл гэх мэт). 6 хэсэг нь тогтвортой эх үүсвэрээс гарган авсан сэргээгдэх эрчим хүчийг ашиглах үндэслэлийг

оруулахад зориулагдсан. С ба D хэсгүүд нь гүйцэтгэж буй үйл ажиллагааны төрлөөс хамааран нэгж үйлдвэрлэлд зарцуулах эрчим хүчийг тооцоход ашиглагдана (жишээ нь, идээлсэн арьснаас эцсийн боловсруулалт хүртэл, эсвэл хагас боловсруулсан арьснаас эцсийн боловсруулалт хүртэл гэх мэт).

Асуулт 4: Үйлдвэрийн нийт эрчим хүчний хэрэглээний хэдэн хувийг нь тогтвортой эх үүсвэртэй сэргээгдэх эх үүсвэрээс* бүрдүүлж байгаа эсэхийг тодорхойлох зорилготой.

Асуулт 5: нь компани бусад байгууллагын өмнөөс ажил гүйцэтгэдэг бол ашиглагддаг эрчим хүчний хэмжээг нэг метр квадрат арьс боловсруулалт тутамд тус бүрээр нь тодорхойлон бичихийг шаарддаг.

2.12 БҮЛЭГ 11 – УСНЫ ХЭРЭГЛЭЭ

Энэхүү хэсэгт үйлдвэрлэсэн нэгж бүтээгдэхүүн тутамд ашигладаг цэвэр усны хэрэглээг үнэлнэ. Дахин ашиглах усны хэрэглээнд онооны урамшуулал өгнө.

Асуулт 1: Байгууллагын өмнөөс ажил гүйцэтгэсэн бүх гүйцэтгэгчдийн жагсаалт, тэдний хариуцсан үйл ажиллагаанууд, боловсруулсан арьсны талбай болон нэг метр квадрат арьсанд ашигласан усны хэмжээний талаар мэдээлэл өгнө.

Асуулт 2: Ашигласан цэвэр усны хэмжээг тодорхойлохыг шаардах бөгөөд үүнийг усны эх үүсвэрүүдээр (жишээ нь, хотын усан хангамжийн систем, гүний худгууд, гол мөрөн гэх мэт) хувааж гаргана.

Асуулт 3: Жилд тухайн боловруулах газарт орж ирсэн усны хэмжээг лавладаг (цэвэр ус, ДЦБ эсвэл ХЦБ-д цэвэрлэсний дараа дахин ашигласан ус гэх мэт).

Асуулт 4: Бүх орж ирж буй усны эх үүсвэрүүдийг зөв, үр дүнтэй хэмжиж байгаа эсэх нотолгоог шаарддаг. Зурган баримт өгөх шаардлагатай, эс бөгөөс энэ хэсгийн онооноос 40 оноо хасагдана.

Усны хэрэглээ нь сүүлийн 24 сарын мэдээллээр баталгаажсан байх ёстой. Хэрэв тухайн сарын мэдээлэл байхгүй бол, 5-р асуултын дагуу хэсгийн онооноос 10 оноо хасагдана.

Асуулт 5: Усны хэрэглээг үйл ажиллагааны төрлөөр нь (жишээ нь, түүхий арьснаас вэт блү, вэт блү-ээс краст хүртэл гэх мэт) хуваан гаргахыг шаарддаг бол 6b ба 6c асуултууд нь компанийн одоогийн усны хэрэглээний түвшинг асуудаг.

Асуулт 7: Үйлдвэрлэлийн орчинд ажиллаж буй цооног эсхүл худаг байгаа эсэхийг лавлана.

Асуулт 8: Сүүлд хийгдсэн үнэлгээнээс хойш арьс шир үйлдвэрлэгчийн боловсруулалтын хүрээ өөрчлөгдсөн эсэхийг лавладаг.



2.13 БҮЛЭГ 12 – АГААРЫН БОЛОН ДУУ ЧИМЭЭНИЙ БОХИРДОЛ ТҮҮНИЙ ЯЛГАРАЛ

Энэ хэсэгт хүрээлэн буй орчинд үйлдвэрээс ялгарах хаягдал, гаргаж буй дуу чимээний менежмент болон шаардлагатай бүртгэл, менежмент, хяналтыг үнэлэх бөгөөд 20 асуултаас бүрдэнэ.

Асуулт 1: Тухайн байгууллага агаарын ялгаруулалтын бүртгэл гаргасан эсэхийг асуудаг. Бүртгэлийн нарийвчлалаас шалтгаалан оноо өгнө (жишээ нь, ялгаруулалтын цэгүүдийн жагсаалт эсвэл диаграм, тэдгээр цэг тус бүрээс ялгарч буй бохирдолын элементүүдийн төрөл гэх мэт). Хэрэв бүртгэл хийгдээгүй бол -40 оноо авна.

Асуулт 2: Ялгаруулалтыг хязгаарлах төхөөрөмж шаардлагатай байгаа эх үүсвэрийн жагсаалтыг гаргахыг шаардана. Хамаарах эх үүсвэр бүрт шаардлагатай хязгаарлах төхөөрөмжийн төрөл болон тус төхөөрөмж ямар бохирдуулагчийг хязгаарлах зориулалттайг тодорхойлох, төхөөрөмжүүдийн тоо зэргийг мэдээлэх ёстой.

Асуулт 3: Ялгаруулалтыг хязгаарлах төхөөрөмж шаардлагагүй эх үүсвэрүүдийн жагсаалтыг гаргахыг шаарддаг. Мөн энэ төхөөрөмжүүд яагаад шаардлагагүйг тайлбарлах ёстой. Хэрэв өгсөн тайлбар хангалтгүй эсвэл аудитор төхөөрөмж шаардлагатай гэж үзсэн тохиолдолд 3-р асуултын жагсаалтанд байгаа эх үүсвэрийг 2-р асуултын жагсаалт руу шилжүүлэх эрхтэй.

Асуулт 4: Ажиллаж байгаа агаарын ялгаруулалтыг хянах төхөөрөмжүүдийн хувийг тооцоход ашиглагдана. Ажиллахгүй эсвэл суурилагадаагүй төхөөрөмжүүд оноо алдах шалтгаан болно.

Асуулт 5: Байгууламжид ашиглагдаж буй төхөөрөмжүүдэд урьдчилан сэргийлэх засвар үйлчилгээний хөтөлбөр байгаа эсэхийг лавладаг. Засвар үйлчилгээний албаны хуваарь зөвлөмжтэй нийцэж буйг харуулбал илүү оноо өгнө.



Асуулт 6: Хаягдал эсвэл дайвар бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн орчинд эсхүл өөр байршилд шатаадаг эсэхийг лавлана. Шатаалт нь тодорхой параметруудтай хянагдсан үйл явц байх ёстой бөгөөд хяналтгүйгээр шатах үйл явц биш гэдгийг анхаарах шаардлагатай. Хэрэв хяналтгүйгээр шатаалт хийгдсэн бөгөөд хяналтын нотолгоо байхгүй бол аудит автоматаар унана.

Асуулт 7: Тусгай зөвшөөрлийн нөхцөлийг хангахын тулд ялгаруулалтын хяналт эсхүл хяналт шаардлагатай бол байгууллага үүнийг мэдээллэх хэрэгтэй.

Асуулт 8: Бойлерийн яндангийн ялгаруулалтын хяналтыг ямар давтамжтай хянадаг болохыг тодорхойлох зорилготой. Өнгөрсөн 24 сарын хугацааны хяналтын дата мэдээлэл, нотолгоог өгөх шаардлагатай. Хэрэв зөвшөөрөлд заасны дагуу гуравдагч талын шинжилгээ хийгдсэн бол хамгийн өндөр оноо өгнө. Хэрэв ийм заалт байхгүй бол гуравдагч талын шинжилгээг жил тутам хийсэн тохиолдолд өгдөг.

Асуулт 9: Бойлерийн яндангаас бусад яндангаас ялгарах хийнд хяналт хийх давтамжийг лавладаг бөгөөд мөн өнгөрсөн 24 сарын хяналтын нотолгоо шаардлагатай.

Асуулт 10: Аммиакийн хяналт (эсвэл үнэлгээ) хийхэд зориулагдсан. Хамгийн өндөр оноог сар бүр ажилчидтай ойр байдаг ялгарал гарч буй цэгт болон байгууламжийн гадна хэсэгт хяналт хийсэн тохиолдолд өгдөг.

Асуулт 11: Агаарын ялгаруулалтыг хянадаг байгууллагын нэрийг тодорхойлохыг шаардана.

Асуулт 12: Агаарын ялгаруулалтын талаар дүгнэлт өгөх зорилготой. Зуух, шүршигч машинууд болон бусад эх үүсвэрүүдээс гарах янз бүрийн ялгаруулалтыг, жилийн дундаж болон зохицуулалтын хязгааруудыг хамт тэмдэглэх ёстой.

Асуулт 13: Байгууламж дотор, дотор агаарт болон талбайн захаар үнэр гарч байгаа эсэхийг илэрүүлдэг байхыг шаарддаг. Хөрш зэргэлдээх газруудаас агаар бохирдуулж байх магадлалтай эх үүсвэрүүдийг мөн тодорхойлох хэрэгтэй бөгөөд зай, байршил, бохирдуулагчдын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг өгнө. Энэ мэдээлэл нь 14 болон 15-р асуултуудад ашиглагдана.

Асуулт 16: Арьс өнгөлөх үйл явцад ашиглагдсан уусгагчийн нийт хэмжээг тооцоход зориулагдсан. Уусгагчийн хэмжээнээс болон мэдээлэл цуглуулах давтамжаас хамааран байгууллага -5-аас 10 хүртэлх оноо авна.


Асуулт 17: Гүйцэтгэгчийн VOC (дэгдэмхий органик нэгдлүүд) ялгаруулалтыг мэдэгдэхийг шаарддаг. Гүйцэтгэгчийн нэр, тэдний үйл ажиллагаа болон боловсруулсан арьсны талбайг мөн мэдүүлэх ёстой. ДОН-ийн ялгаруулалтыг нэг метр квадрат арьс боловсруулахад ялгарсан граммаар илэрхийлнэ.

Асуулт 18: Байгууллага болон гүйцэтгэгчдээс ялгарсан ДОН-ийн хэмжээнээс хамаарч оноо тооцдог.

Асуулт 19: Уусгагчаар тосгүйжүүлэлт хийх үед ялгардаг ДОН-ийн талаар ашиглагддаг. Хэрэв уусгагчийн ялгаруулалтын хэмжээ 100 граммаас илүү байвал -10 оноо авна; бусад тохиолдолд оноо 0 байна.

Асуулт 20: Дуу чимээний ялгаруулалтын тухай байна. Байгууламжийн гадна талын дууны түвшинг хэмжиж, хянах шаардлагатай бөгөөд дууны түвшинг жилд дор хаяж гурван удаа, өдөрт хэд хэдэн удаа, өөр өөр байршлуудад шалгаж, хяналт хийсэн тохиолдолд өндөр оноо өгнө. Өнгөрсөн 12 сард хяналт хийгдээгүй бол оноо хасагдана.

2.14 БҮЛЭГ 13 – ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ



Энэ хэсэгт үйлдвэр нь үйлдвэрлэлийн орчинд үүссэн хог хаягдлын менежмент, хяналтыг үнэлэх бөгөөд хог хаягдлын бүртгэл, ангилал, хадгалалт болон зайлуулалт хийдэг байх шаардлагатай. Энэ хэсэг нь 36 асуултаас бүрдэнэ.

Асуулт 1: Тухайн байгууламжид хог хаягдлын менежментийн албан ёсны журам байгаа эсэхийг асууна. Энэхүү журам нь хог хаягдлыг (аюултай болон аюулгүй) таних, цуглуулах, хадгалах, устгах заавар, мөн хог хаягдлыг удирдахад оролцож буй хүмүүсийн жагсаалтыг агуулсан байх ёстой.

Асуулт 2: Хог хаягдлын менежментийн журамд тухайн бүс нутгийн зохицуулалтын стандартыг тусгасан эсэхийг лавлана.

Асуулт 3: Тухайн байгууллагын хог хаягдлын журам нь стандарттай нийцэж байгаа гэдгийг нотлох баримт өгөх шаардлагатай.

Энэ нь эрх бүхий байгууллагын үзлэг хийсэн (хог хаягдалтай холбоотой залруулах арга хэмжээ шаардлагагүй),

эсвэл эрх бүхий байгууллагуудад компанийн журамыг мэдээлсэн баримтаар нотлогдож болно.

Асуулт 4, 5, 6: Хог хаягдлын менежменттэй холбоотой эрх бүхий байгууллагуудад хамаарна. Тодруулбал, 4-р асуулт нь хог хаягдлын менежментийн асуудалд оролцдог эрх бүхий байгууллагуудыг дурдсан эсэхийг, 5-р асуулт нь сүүлийн 24 сарын хугацаанд эрх бүхий байгууллага үзлэг хийсэн эсэхийг, 6-р асуулт нь тухайн байгууламжийг зөвшөөрөл болон хууль эрх зүйн шаардлагад нийцсэн эсэхийг шалгах талаар байна.

Асуулт 7: Компани аюултай болон аюулгүй хог хаягдал, дайвар бүтээгдэхүүн болон хэсэгчилсэн хаягдал зэрэг ангилсан хог хаягдлын төрлийг болон тоо хэмжээг бүртгэсэн эсэхийг асууна.

7-р асуултын төгсгөлд LWG нь хог хаягдал болон дахин боловсруулалтын тодорхойлолтыг өгдөг. Мөн дахин ашигласан, дахин боловсруулсан, сэргээн ашигласан, эсвэл устгасан хог хаягдлын төрлийг, тоо хэмжээг тодорхойлоход ашиглах хүснэгтийг бөглөнө.

Асуулт 8: Дахин боловсруулалт хийгддэггүй хог хаягдлыг үйлдвэрлэлийн орчноос зайлуулж, зохистой бөгөөд хуулийн хүрээнд устгал хийдгийг илтгэх зорилгоор эдгээр хаягдлын тээвэрлэгч, устгал хариуцсан төлөөлөгчийн мэдээллийг лавлана (компанийн бүртгэлийн дугаар, зөвшөөрлийн дугаар, зөвшөөрлийн хүчинтэй хугацаа)

Асуулт 9: Хаягдлыг зохих ёсоор зайлуулж, дахин боловсруулах хууль ёсны маршрут байгаа эсэхийг асууна.

Асуулт 10: Компани нь аюултай хог хаягдлын цуглуулалт, устгалтай холбоотой бүртгэлийг хадгалдаг эсэхийг асууна. Үүнд манифест эсвэл цуглуулгын баримтууд багтана. Хэрэв ямар нэгэн бүртгэл байхгүй эсвэл дутуу бол амжилтгүйд тооцогдоно.

Асуулт 11: Аюулгүй материалын цуглуулалт, устгалтай холбоотой бүртгэлийн хувьд 10-р асуулттай ижил. Хэрэв компани эдгээр бүртгэлийг хадгалаагүй бол онооноос 6 оноо хасагдана.

Асуулт 12, 13: Арьсанд агуулагдах давсны хэмжээг илрүүлэх ба тухайн илүүдлийг хэрхэн зайлуулсан тухай (12-р асуулт), мөн давсны эцсийн хэрэглээ буюу гаргаж авсан илүүдэл давсыг хэрхэн ашигласаныг (13-р асуулт) тодорхойлоно. Хэрэв давсыг хяналтгүй хаясан бол шалгалт амжилтгүйд тооцогдоно. Хэрэв давс зайлуулахад хогийн цэг ашигласан бол хогийн цэгийн үйл ажиллагааны зөвшөөрлийн дэлгэрэнгүйг өгөх шаардлагатай.

Асуулт 14-24: Байгууламжийн үйл ажиллагаанаас үүссэн хаягдал, дайвар бүтээгдэхүүний эцсийн хэрэглээг тодорхойлох тухай байх ба үүнд арьс шир, өөдөс, үс, зоргодос гэх мэт зүйлс орно. Хог хаягдлыг дахин ашиглах, сэргээн ашиглах болон дахин боловсруулалтын тодорхойлолтыг мөн шаардана.

Асуулт 25, 26: Зөвхөн тухайн байгууллага хаягдлыг түлш болгон ашигладаг тохиолдолд хамаарна. Энэ тохиолдолд байгууллага жил бүр түүнээс гарах хий (25-р асуулт) болон бохирдуулагч үлдэгдлийг яаж (26-р асуулт) хянадаг болохыг тодорхойлох ёстой.

Асуулт 27: Байгууллагийг дайвар бүтээгдэхүүний (дахин ашиглах эсвэл сэргээх зорилгоор) хэмжээг хянадаг эсэхийг тодорхойлох зорилготой бөгөөд энэ нь үйл ажиллагааг хянахад чухал үүрэгтэй.

Асуулт 28: 27-р асуулттай төстэй. Хаягдлын хэмжээг (устгах шаардлагатай) хянах ёстой бөгөөд ингэснээр хэт их хаягдал үүсээгүйг баталгаажуулна.

Асуулт 29, 30: хаягдал хийх хоосон савнуудыг зохион байгуулах талаар тодруулана. 29-р асуулт нь аюултай химийн бодисын савнуудын, 30-р асуулт нь аюулгүй химийн бодисын савнуудын хадгалалтын талаар байна. Хэрэв хадгалалт хөрс бохирдуулах эрсдэлтэй байвал аудит автоматаар унана. Аль аль асуултууд гэрэл зургаар нотологдоно.

Асуулт 31, 32: 29, 30-р асуултуудтай төстэй бөгөөд аюултай болон аюулгүй хог хаягдлыг газар дээр хадгалахтай холбоотой. Мөн гэрэл зургийн нотолгоо заавал шаардагдана.

Асуулт 33: Хог хаягдлыг хэрхэн зайлуулдаг аргуудыг жагсаахыг шаарддаг. Хэрэв аудитад хамрагдсан байгууллага өөрийн хог хаягдлын байгууламжийг эзэмшиж, удирддаг бол талбайгаас гадуурх зайлуулах аргуудыг мөн хамт оруулах шаардлагатай. Үүний зэрэгцээ, хог хаягдлыг зайлуулах явцыг нотлох гэрэл зургийн баримт болон холбогдох зөвшөөрлийн дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан байх ёстой.

Асуулт 34, 35: Аюултай (34-р асуулт) болон аюулгүй химийн бодисын савнууд (торх, тавиур гэх мэт)-ын эцсийн байдлыг тодорхойлох зорилготой.

Асуулт 36: Аюулгүй химийн бодисын савнуудыг цэвэрлэх ямар нэгэн процедур байгаа эсэхийг тодруулахад зориулагдсан.

2.15 БҮЛЭГ 14 – БОХИР УС ЦЭВЭРЛЭГЭЭ

Энэхүү хэсэгт үйлдвэрийн өөрийн үйлдвэрлэлийн орчинд эсхүл үйлчилгээ үзүүлэгч гуравдагч талын үйлдвэрлэлийн орчин дахь шингэн хог хаягдлын менежментийг үнэлнэ. Бохир усыг хуулийн хүрээнд зайлуулахыг шаарддаг ба тохирох төрлийн технологи ашиглан усны чанарыг зорьсон түвшинд хүргэсэн үйлдвэрүүдэд өндөр оноо өгнө.

Асуулт 1: гарч буй усыг үр дүнтэй хэмжиж байгаа эсэхийг лавладаг. Үр дүнтэй хэмжилтийг автомат тоолуур, жишээ нь, Паршалл сувагтай хэт авианы хэмжилт, шугамын тоолуур, эсвэл эзлэхүүн нь тодорхой савнуудтай ачааны машинаар хийгдсэн шилжүүлгийн бичиг баримттайгаар хийж болно. Үйлдвэрлэлийн бус зориулалтаар ашиглагдаж буй ус ч мөн хэмжигдэх ёстой. Гарч буй усыг хэмжиж байгаа тохиолдолд гэрэл зургийн нотолгоо заавал байх ёстой.

Асуулт 2 нь нийт орж ирсэн усны хэдэн хувь нь effluent болж гарч байгааг тооцож, тайлагнахыг шаарддаг.

Асуулт 3 нь ямар төрлийн бохир ус зайлуулагдаж байгааг тодорхойлохыг шаардана: арьс шир боловсруулах явцад үүссэн процессын бохир ус, ариун цэврийн бохир ус (жорлон, шүршүүрийн ус гэх мэт), гадаргын ус (борооны ус).

Асуулт 4 нь гадаргын ус, ариун цэврийн бохир ус, процессын бохир усны тусдаа зайлуулах систем байгаа эсэхийг тодорхойлохыг шаарддаг. Дээрх системүүдийн тооноос хамааран оноо авна; системүүд байхгүй бол -10 оноо авна.

Асуулт 5 нь бохир усыг хэрхэн цэвэршүүлж байгааг тодруулахыг шаарддаг. Байгууллагын өөрийн эзэмшлийн цэвэрлэх байгууламж эсвэл гадны цэвэрлэх байгууламж ашиглаж байгаа бол хамгийн өндөр оноо авна. 24 сарын дүн шинжилгээний тайланг ISO 17025 сертификаттай лабораториос гаргуулсан бол бас оноо авна. Хэрэв байгууллага өөрөө цэвэршүүлэлт хийгээгүй, эсвэл шаардлагад нийцээгүй бол аудит автоматаар унана.

Асуулт 6 нь ХЦБ/ДЦБ цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааны зөвшөөрөл болон бохир усны дундаж үзүүлэлтүүдийг зөвшөөрлийн хязгааруудтай харьцуулан мэдээлэхийг шаарддаг.

Асуулт 7 нь давсны (хлоридоор илэрхийлэгдсэн) ялгаралтыг хэмжихийг шаардана. Хяналттай буюу зөвшөөрөгдсөн газарт хуулийн дагуу зайлуулагдаж байгаа бол үүнд хамаарахгүй.

Асуулт 8 нь цэвэршүүлсэн бохир ус хэрхэн байгаль орчинд нэвтэрч байгааг тодруулахыг шаарддаг: усалгаанд ашиглаж байгаа эсэх, дотоод усны зам руу, эргийн болон түрлэгийн ус руу, эсвэл ууршилтаар зайлуулагдаж байгаа эсэх.

Асуулт 9: Давсаар хадгалсан арьснаас угаагдсан давсны эцсийн хаягдлын байршлыг тодорхойлох шаардлагатай. Давсны хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжид илгээгддэг бол зураг хэлбэрээр баталгаажуулалт шаардлагатай. Хэрэв давсыг газарт нөхөн сэргээж байгаа бол мөн баталгаажуулах баримт өгөх шаардлагатай. Хэрэв хууль ёсны устгалын маршрутгүй бол шалгалт амжилтгүйд тооцогдоно.

Асуулт 10: Шинжилгээний дүнгээс дундаж утгыг (сүүлийн 24 сарын мэдээлэл дээр үндэслэн) ба параметрийн хууль ёсны хязгааруудыг зааж өгөх шаардлагатай.

Асуулт 11: Бохир усны хаягдлын чанарын хяналтын давтамжийг мэдэгдэх шаардлагатай. Хэрэв хяналт улиралд нэгээс бага удаа хийгдсэн бол шалгалт амжилтгүйд тооцогдоно.

Асуулт 12: Бохир усны хаягдлын гуравдагч талын хяналтын давтамжийг тодорхойлох шаардлагатай; хэрэв улиралд нэгээс бага удаа хийсэн бол шалгалт амжилтгүйд тооцогдоно.

Асуулт 13-24: Туршилтын үр дүнгээр жил бүрийн дундаж ялгаралтын үзүүлэлтүүдийг тодорхойлох тухай (Химийн хүчилтөрөгчийн хэрэглээ (COD), Биологийн хүчилтөрөгчийн хэрэглээ (BOD), нийт Кьелдалийн азот, нийт азот, аммонийн азот, түдгэлзүүлсэн хатуу бодис, нийт хром, хром VI, сульфид, тос ба тосны хэмжээ, фосфор, фенол). Тухайн бодисын агууламж бага байх тусам оноо өндөр байна.

